



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/39/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: Д.Мядагмаа
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/144
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭНЭРЭЛ
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ж.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА.

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн газраас 48,761.3 мянган төгрөгийн вакцин, нэг удаагийн хэрэгсэл болон хөдөлмөр хамгааллын хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч бараа материалын дансанд орлогоор бүртгэж авсан байна.

Аудитын гол асуудал

Улсын бүртгэлийн гэрчилгээ дахь дүрмийн сангийн хэмжээ нь 80,000.0 мянган төгрөг, Засгийн газрын сан 212,918.2 мянган төгрөг бөгөөд 132,918.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.” Гэж заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь санхүүжиж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>58,242,604.65</u>	<u>104,641,415.14</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,407,702.09	71,027.51
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,407,702.09	71,027.51
3121	Төгрөг	9,407,702.09	71,027.51
31211	Төрийн сангийн харилцах	9,407,702.09	71,027.51
33	АВЛАГА	00.00	41,217,486.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	60,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	41,157,486.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,834,902.56	63,352,901.63
351	Түүхий эд материал	29,382,191.00	35,006,350.07
35110	Тусгай зориулалттай материал	15,538,391.00	20,540,009.03
35130	Эм боох материал	13,843,800.00	14,466,341.04
354	Хангамжийн материал	19,452,711.56	28,346,551.56
35420	Аж ахуйн материал	286,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	19,166,711.56	28,346,551.56
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>241,558,458.83</u>	<u>240,279,175.36</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	241,558,458.83	240,279,175.36
392	Биет хөрөнгө	215,306,958.83	214,027,675.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	124,312,129.92	124,312,129.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,761,680.15)	(15,493,128.15)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,750,000.00	12,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,585,937.50)	(5,179,687.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	96,283,226.22	110,194,239.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,618,583.02)	(37,219,896.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,433,121.82	26,313,121.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,222,761.26)	(5,047,295.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,994,447.28	4,994,447.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,277,004.48)	(1,596,255.60)
393	Биет бус хөрөнгө	26,251,500.00	26,251,500.00
39301	Програм хангамж	137,500.00	137,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	26,114,000.00	26,114,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>299,801,063.48</u>	<u>344,920,590.50</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>299,801,063.48</u>	<u>344,920,590.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	299,801,063.48	344,920,590.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	212,918,175.95	212,918,175.95

Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	212,918,175.95	212,918,175.95
512	Хуримтлагдсан үр дүн	80,750,689.40	125,870,216.42
51210	Өмнөх үеийн үр дүн	80,750,689.40	80,750,689.40
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	45,119,527.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,132,198.13	6,132,198.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>299,801,063.48</u>	<u>344,920,590.50</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	697,060,659.89	731,937,144.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	108,056,048.72	54,794,987.25
120	Нийтлэг татварын бус орлого	108,056,048.72	54,794,987.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	101,517,068.72	48,761,387.25
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	101,517,068.72	48,761,387.25
120009	Бусад орлого	6,538,980.00	6,033,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	589,004,611.17	677,142,157.38
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	589,004,611.17	677,142,157.38
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	589,004,611.17	677,142,157.38
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	729,197,529.98	686,817,617.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	729,197,529.98	686,817,617.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	706,604,529.98	678,742,617.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468,056,883.00	468,176,935.00
210101	Үндсэн цалин	468,056,883.00	468,176,935.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,989,740.45	56,633,278.31
210202	Тэтгэмжийн даатгал	56,989,740.45	56,633,278.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,123,455.00	6,485,455.00
210302	Түлш, халаалт	5,493,455.00	5,603,455.00
210303	Цэвэр, бохир ус	630,000.00	882,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,164,085.00	17,172,811.00
210401	Бичиг хэрэг	7,860,585.00	6,899,110.00
210402	Тээвэр, шатахуун	2,590,810.00	3,086,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,794,090.00	2,210,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	678,600.00	1,342,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	947,100.00	792,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,292,900.00	2,841,821.00
2105	Нормативт зардал	117,673,952.54	91,617,734.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	117,673,952.54	91,617,734.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,365,500.00	939,950.00
210604	Урсгал засвар	5,365,500.00	939,950.00

Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	727,000.00	1,042,400.00
210702	Дотоод албан томилолт	727,000.00	1,042,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	588,876.00	1,973,796.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	209,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,936.00	33,936.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	52,240.00	78,360.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	127,700.00	140,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,915,037.99	34,700,257.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,176,220.00	12,159,310.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,099,120.00	1,470,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,639,697.99	21,070,296.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,593,000.00	8,075,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,593,000.00	8,075,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,593,000.00	8,075,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-32,136,870.09	45,119,527.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-32,136,870.09	45,119,527.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>674,707,745.17</u>	<u>643,295,975.38</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,538,980.00	6,033,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,538,980.00	6,033,600.00
120009	Бусад орлого	6,538,980.00	6,033,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	668,168,765.17	637,262,375.38
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	668,168,765.17	637,262,375.38
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	1,277,704.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	668,168,765.17	635,984,671.38
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>643,219,902.45</u>	<u>634,392,229.96</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	643,219,902.45	634,392,229.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	620,091,402.45	624,836,425.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468,056,883.00	468,236,935.00
210101	Үндсэн цалин	468,056,883.00	468,236,935.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,989,740.45	56,633,278.31
210202	Тэтгэмжийн даатгал	56,989,740.45	56,633,278.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,123,455.00	6,485,455.00
210302	Түлш, халаалт	5,493,455.00	5,603,455.00

Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	630,000.00	882,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,232,585.00	19,552,651.00
210401	Бичиг хэрэг	7,860,585.00	6,864,910.00
210402	Тээвэр, шатахуун	2,590,810.00	2,816,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,794,090.00	2,223,700.00
210404	Ном, хэвлэл	00.00	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	678,600.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,729,600.00	4,791,340.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,578,900.00	2,555,821.00
2105	Нормативт зардал	38,117,523.00	50,329,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,298,523.00	45,601,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	819,000.00	4,728,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,515,500.00	6,414,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,150,000.00	4,859,800.00
210604	Урсгал засвар	5,365,500.00	1,554,950.00
2107	Томилолт, зочны зардал	727,000.00	1,042,400.00
210702	Дотоод албан томилолт	727,000.00	1,042,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	588,876.00	1,973,796.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	209,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,936.00	33,936.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	52,240.00	78,360.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	127,700.00	140,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,739,840.00	14,167,860.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,640,720.00	12,697,210.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,099,120.00	1,470,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,128,500.00	9,555,804.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,128,500.00	9,555,804.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	1,277,704.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,128,500.00	8,278,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>31,487,842.72</u>	<u>8,903,745.42</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,113,700.00	18,240,420.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,113,700.00	18,240,420.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,113,700.00	18,240,420.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,113,700.00	18,240,420.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(22,113,700.00)</u>	<u>(18,240,420.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,374,142.72	(9,336,674.58)

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,559.37	9,407,702.09
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,407,702.09	71,027.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,804,175.95	5,717,818.00	(54,376,253.18)	138,145,740.77
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,804,175.95	5,717,818.00	(54,376,253.18)	138,145,740.77
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(6,794,313.72)	(6,794,313.72)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,918,175.95	6,132,198.13	80,750,689.40	299,801,063.48
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,918,175.95	6,132,198.13	80,750,689.40	299,801,063.48
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	45,059,527.02	45,059,527.02
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,918,175.95	6,132,198.13	125,810,216.42	344,860,590.50

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 315,118.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 60.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 315,058.2 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулагдаагүй 6 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 80.8 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 10,989.1 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин, НДШ-ийн зардалтай холбоотой

Илрүүлэлт: Жирэмсний амралтаа авсан ажилтныг Нийгмийн даатгалын тайланд 01 кодоор тайлагнасан. Үүнээс үүдэн нийгмийн даатгалд 80.8 мянган төгрөгийн илүү зардал гаргасан байгаа нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" 17.1.3 "Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах" гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдээдлийг хангахгүй байна.*

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тайланд тусгай кодоор тайлагнагдаж байгаа ажилтнуудын кодыг хянаж илгээж байх.

2. Анхан шатны баримттай холбоотой

Илрүүлэлт: Тайлант оны зардал болон анхан шатны баримт, төлбөрийн ибаримтын системийг тулган шалгахад 13,498.0 мянган төгрөгийн ибаримтгүй худалдан авалт хийгдсэн байна. Энэ нь *Татварын ерөнхий хууль 28.5 Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэн заалттай тус тус нийцэхгүй бөгөөд “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Өгсөн зөвлөмж: Зардал болон анхан шатны баримтыг төлбөрийн И баримтыг тухай бүх авч тулгаж И баримтыг үндэслэн зардал болон худалдан авалтыг бүртгэж байх.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт: Нийт 21,087.1 мянган төгрөгийн 18 үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг -1 ээр оруулан огт элэгдэл тооцоогүй нь *“Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн” 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг засаж оруулан элэгдэл тооцох.

4. Зардлын бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Бараа ажил үйлчилгээний бусад зардал дансанд Нийгмийн эрүүл мэндийн зардал, засвар үйлчилгээний зардал, алданги, торгуулийг хамтад нь бүртгэсэн нь НБББББ-тай нийцэхгүй байгаа нь *“Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн” 18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд “Толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Өгсөн зөвлөмж: Цаашид зардлын дансны ангиллыг зөв хийх.

5. Төрийн өмчтэй холбоотой

Илрүүлэлт: Засгийн газрын оруулсан хөрөнгө, Улсын бүртгэлийн гэрчилгээ болон байгууллагын дүрэм хоорондоо 212,838.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь *“Нөхөрлөлийн тухай хуулийн” 2.3 “гишүүн” гэж нөхөрлөлд хөрөнгө оруулсан этгээдийг хэлнэ. Хувь хүн, нөхөрлөл, төрийн эрх бүхий байгууллага гишүүн байж болно гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Өгсөн зөвлөмж: Улсын бүртгэлийн гэрчилгээ болон байгууллагын дүрэмд заасан дүнг залруулах

6. Тайлантай холбоотой

Илрүүлэлт: ААНОАТ-ын тайлан, Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогын дүн хоорондоо 88,641.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байгаа нь *“Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн” 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалттай нийцээгүй байна.*

Өгсөн зөвлөмж: Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайлан залруулах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Томилолт, хоол, унааны мөнгө давхардуулан олгосон	1	60.0			1	60.0	1	60.0		
Дүн	1	60.0			1	60.0	1	60.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2023 оны зардал болон анхан шатны баримт төлбөрийн ибаримтын системийг үндэслэн шалгахад 13,498.1 мянган төгрөгийн ибаримтгүй худалдан авалт хийгдсэн байна	1	13,498.1					1	13498.1
Жирэмсний амралтаа авсан ажилтныг Нийгмийн даатгалын тайланд 01 кодоор тайлагнасан. Үүнээс үүдэн нийгмийн даатгалд 80,850.0 төгрөгийн илүү зардал гаргасан.	1	80.8					1	80.8
Нийт 21,087.1 мянган төгрөгийн 18 үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг -1 ээр оруулан огт элэгдэл тооцоогүй	1						1	
Бараа ажил үйлчилгээний бусад зардал дансанд Нийгмийн эрүүл мэндийн зардал, засвар үйлчилгээний зардал, алданги, торгуулийг хамтад нь бүртгэсэн	1						1	

Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Засгийн газрын оруулсан хөрөнгө 212,838.2 мянган төгрөгийг Улсын бүртгэлийн гэрчилгээ болон байгууллагын дүрэм дээр бүртгэгдээгүй	1	212,838.2					1	212,838.2
ААНОАТ-ын тайлан, Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогын дүн хоорондоо 88,641.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан	1	88,641.2					1	88,641.2
Дүн	6	315,058.3					6	315,058.3

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНТӨГ	1				1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1				1			